



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар САМ - 2024/16

Сүхбаатар сум

Баруунбүрэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн  
хурлын Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн  
хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан  
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 08 дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Сант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах дотоод аудитор, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Т.Мөнхзул, Дотоод аудитор Х.Батбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Баруунбүрэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Баруунбүрэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь улсын бүртгэлийн 3762475 регистртэй, төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131154001 данстай.

Санхүү, татварын баримтад 1 дүгээр гарын үсгийг ИТХ-н нарын бичгийн дарга М.Мөнхцацралт, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Оюунгэрэл нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайлан гаргаж ирсэн байна.

1.5 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр хуралдаанаар сумын ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог баталсан байна.

Сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Нутгийн удирдлага, хууль зүйн хяналтын бодлогын хороо, Хөгжлийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, ХАА, байгаль орчны бодлогын хороо зэрэг Хурлын хороо 4-

4324001129

г байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

1.6 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 4 удаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 2 удаа, багийн иргэдийн Нийтийн Хурал тус бүр 1 удаа хуралдуулсан. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс голлон анхаарч ажилласан байна.

1.7 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд ИТХ-ыг 4 удаа, Нийтийн Хурлыг 1 удаа хуралдуулсан. Сумын ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Сумын ИТХ-ын төлөөлөгчид болон БИНХ-ын зөвлөлийн гишүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэгт ажлын албаны зүгээс голлон анхаарч ажилласан байна.

Үүнд:

№	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдсан огноо	Хурлаар		Ирцийн хувь
		Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэлт (тогтоолын дугаар)	
1	2024.02.01	1. 2024 оны Баруунбүрэн сумын ойн сангаас бэлтгэх хэрэглээний модны дээд хязгаар, газрын нэр батлах тухай	88	71.4
2		2.2024 оны газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөг батлах тухай	87	
1	2024.02.28	1.Сонгуулийн хэсэг байгуулах тухай	89	100.0
1	2024.04.25	1. Сонгуулийн сурталчилгааны нэгдсэн болон зурагт самбарыг байрлуулах байршлыг тогтоох тухай.	90	100.0
2		2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрог байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар төвийг тогтоох тухай	91	
1	2024.05.27	1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хэсэг байгуулах тухай.	92	80.9
1	2024.08.06	1. Сонгуулийн сурталчилгааны нэгдсэн болон зурагт самбарыг байрлуулах байршлыг тогтоох тухай	93	95.2

## Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

### 2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Тус сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу эхний 3 дугаар улирлын байдлаар цахим системд нийт 135 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь хавсралт файлгүй, холбогдох мэдээллийг бүрэн оруулаагүй байгаа бөгөөд энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл шилэн дансанд байршуулах мэдээллийн шаардлагыг хангаагүй байна.

### 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

#### 2.2.1 Батлагдсан төсөв:

2024 онд сумын ИТХ нь хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвийн дагуу орон нутгийн төсвөөс 145,249.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 93,233.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 93,233.3 мянган төгрөгийг зарцуулсан.

#### 2.2.2. 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024 оны эхний 3-р улирал		хэмнэлт/+/ хэтрэлт -/-
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн цалин	90051.7	49602.1	40449.6
2	Нэмэгдэл	16907.5	30018	-13110.5
3	Урамшуулал	12731.3	1015.1	11716.2
4	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын дүн</b>	<b>125690.5</b>	<b>80635.2</b>	<b>45055.3</b>
5	Тэтгэврийн даатгал	7645.6	6865.2	780.4
6	Тэтгэмжийн даатгал	899.8	776.9	122.9
7	ҮОМШӨ ний даатгал	2248.6	388.5	1860.1
8	Ажилгүйдлийн даатгал	449.6	384.7	64.9
9	Эрүүл мэндийн даатгал	0	1615.3	-1615.3
10	<b>Ажил олгогчоос төлөх НД-ын шимтгэл</b>	<b>15711.6</b>	<b>10030.6</b>	<b>5681.0</b>
11	Бичиг хэрэг	1460.9	1100.9	360.0
12	Тээвэр, шатахуун	4688.8	3518.8	1170.0
13	<b>Хангамж бараа материалын зардлын дүн</b>	<b>6149.7</b>	<b>4619.7</b>	<b>1530.0</b>
14	Багаж, техник, хэрэгсэл	1731.2	0	1731.2

15	<b>Эд хогшлын зардлын дүн</b>	<b>1731.2</b>	<b>0</b>	<b>1731.2</b>
16	<b>Дотоод албан томилолт</b>	<b>2420.4</b>	<b>524.0</b>	<b>1896.4</b>
17	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1588.2	1068.0	520.2
18	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	2000.0	927.8	1072.2
19	<b>БГАУ, бараа үйлчилгээний бусад зардлын дүн</b>	<b>3588.2</b>	<b>1995.8</b>	<b>1592.4</b>
20	Бараа үйлчилгээний бусад зардал	15482.0	3682.0	11800.0
21	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15482.0</b>	<b>3682.0</b>	<b>11800.0</b>
22	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулал	9582.0	9582.0	0
23	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1000.0	1000.0	0
24	<b>Урсгал шилжүүлгийн дүн</b>	<b>10582.0</b>	<b>10582.0</b>	<b>0</b>
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>181355.9</b>	<b>112069.2</b>	<b>69286.7</b>

- 1. Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** 2024 оны эхний 3-р улирлын байдлаар үндсэн цалингийн зардал 55.1 хувийн, урамшуулал 8.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол нэмэгдэл цалин 77.5 хувийн хэтрэлттэй байна. Нэмэгдэл цалингийн хэтрэлттэй байгаа шалтгаан нь орон нутгийн нэмэгдэл цалингийн хувь 2024 онд өссөнтэй холбоотой байна.
- 2. ЭМНДШ-ийн зардал:** 2024 оны төсөвт эрүүл мэндийн даатгалын дүнг төсөвлөж өгөөгүйгээс оны эхний 3 дугаар улирлын байдлаар 1,615.3 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн төлж байна.
- 3. Хангамж бараа материалын зардал:** 2024 онд бараа материалын зардалд 6,149.7 мянган төгрөг батлагдаж эхний 3 дугаар улирлын байдлаар 4,619.7 мянган төгрөгийг зарцуулжээ. Бараа материал болон шатахууны зарцуулалтыг шаардах хуудас, маршрутыг үндэслэн зарлагадаж бүртгэсэн байгаа боловч шатахууны замын хуудсыг хөтлөхдөө Зам тээврийн сайдын 390 дугаар тушаалын хавсралтыг мөрдөөгүй байна.
- 4. Томилолтын зардал:** 2024 онд 2,420.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар 524.0 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.
- 5. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж:** 2024 онд 3,588.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар 1,995.8 мянган төгрөг зарцуулсан.
- 6. Бусад зардал:** 2024 онд 15,482.0 мянган төгрөг батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар бараа үйлчилгээний бусад зардалд 3,682.0 мянган төгрөгийг зарцуулсан баримттай байна.
- 7. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал:** 2024 онд сумдад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдад таван жил ажилласны мөнгөн урамшуулал олгох 9,582.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 100.0 хувь байна.

### **2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт**

**Үндсэн хөрөнгө:** ИТХ нь 2024 оны эхэнд авто тээврийн хэрэгсэл 7,000.0 мянган төгрөг тоног төхөөрөмж 13,762.9 мянган төгрөг, тавилга эд хогшил 21,359.4 мянган төгрөг хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

ИТХ-н үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа авто тээврийн хэрэгслийг 2017 онд худалдан авч хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн боловч өнөөдрийг хүртэл байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа”-тай тулган баталгаажуулахыг зөвлөв.

**Бараа материал:** 2024 онд 2,844.3 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй төсвийн хөрөнгөөр 10,540.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулан 3-р улирлын байдлаар 8,932.5 мянган төгрөгийн зарцуулалт хийж 4,451.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант хугацаанд ГХУСС зөвлөлийн зардалд 927.7 мянган төгрөг, шатахууны зардалд 3,518.8 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1,100.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан баримтаар нотлогдож байна.

### **Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.**

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		42122.3	2844.3
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан		10540.1
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан		
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан		
5	Бусад			
6	Орлогын дүн		0.0	10540.1
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт		8932.5
8	Байгууллагуудад шилжүүлсэн	шилжүүлсэн		
9	Акталж данснаас хассан	тушаалаар		
10	Зарлагын гүйлгээний дүн		0.0	8932.5
11	Оны эцсийн үлдэгдэл		42122.3	4451.9

## 2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	ИТХ		БИНХ	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Үндсэн цалин	96051.7	44874.2		4727.9
2	Нэмэгдэл цалин	16907.5	30018.0		
3	Урамшуулал	5199.5	136.9	7531.8	878.2
5	<b>Цалин хөлс нэмэгдэл дүн</b>	<b>118158.7</b>	<b>75029.1</b>	<b>7531.8</b>	<b>5606.1</b>
5	<b>Ажил олгогчоос төлөх НДШ</b>	<b>14870.1</b>	<b>9378.6</b>	<b>841.5</b>	<b>651.9</b>
<b>Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн</b>		<b>133028.8</b>	<b>84407.7</b>	<b>8373.3</b>	<b>6258.0</b>
<b>Орон тооны мэдээлэл</b>		<b>3</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>3</b>

Сумын ИТХ нь 3, багийн иргэдийн нийтийн хурал 3, нийт 6 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 141,402.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 90,665.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэгдэл цалинг 13,110.5 мянган төгрөгөөр үндсэн цалингийн зардлаас шилжүүлэн олгосон байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад: ЭМД-ыг 2024 оны төсөвт суулгаж өгөөгүйгээс 1,615.3 мянган төгрөгийг зардал хооронд шилжүүлэн төлсөн байна. Мөн БИНХ-ын дарга нарын урамшуулалд 4727.9 мянган төгрөгийг урамшууллыг зардлаас зардал хооронд гүйлгэн үндсэн цалингийн зардлаас олгосон байна.

## 2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх томоохон худалдан авалт хийгдээгүй байна.

## 2.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих

### 1. Анхан шатны баримтын бүрдэл

- Бараа материалын худалдан авалт, анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалт нь хууль, журмын дагуу бүртгэгдсэн байна.

### 2. Шатахуун зарцуулалт

“НИК” ХХК-тай гэрээ байгуулж, шатахууны карт ашиглан эхний хагас жилийн байдлаар 3,518.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Анхан шатны баримтын бүрдлийг тулган шалгахад:

- Жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтөлсөн боловч автомашины 100 км-д зарцуулах шатахууны нормыг /Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Автомашины 100км гүйлтэд зарцуулах жишиг норм”/ мөрдөөгүй.

### 3. ИТХ хуралдааны зардал

- Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны хоолны зардалд 3,682.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.
  - ИТХ-ын хуралдааны хоолны зардлыг баталсан төсвийн дүнгээр зарцуулсан байгаа нь анхан шатны баримт ирцийн бүртгэл, хурлын тэмдэглэлд үндэслэн гүйцэтгэлээр зарцуулаагүй байна.

## 2.7 Өмнөх шалгалтын талаар

Хүснэгт 6.

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн шийдвэрлэлт	2023 он				
	Үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Албан шаардлага	1	684.0	1	684.0	100.0%
<b>Нийт дүн</b>		<b>684.0</b>		<b>684.0</b>	<b>100.0%</b>

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 онд ИТХ-ын бараа үйлчилгээний зардлын батлагдсан төсвөөс 684.0 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл болох ус буцалгагч, усны суурь, чихрийн таваг зэрэг зүйл худалдан авсан зөрчил илэрсэн байна. Албан шаардлагын биелэлт хэрэгжсэн байна.

### Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ИТХ-ын 2024 оны эхний 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн бүртгэл, шилэн дансны цахим хуудасны хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

**Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:**

**Илрүүлэлт 1.** ИТХ-н төлөөлөгчдийн хуралдааны цай, хоолны 3,682.0 мянган төгрөгийн зардлыг гүйцэтгэлээр бус төсөвлөсөн дүнгээр бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт** Цаашид ИТХ-н хуралдааны цай, хоолны зардлыг хуралдаанд оролцсон төлөөлөгч нарын ирцийн бүртгэлд үндэслэн гүйцэтгэлээр бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2.** ИТХ-ын дарга нь хууль, эрхийн хүрээнд заагдаагүй хурлын ажлын албаны төсвийг зарцуулах шийдвэр гаргаж 12,962.4 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна." Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь "Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана", гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт** ИТХ-н төсөв санхүүтэй холбоотой шийдвэрийг хурлын ажлын албаны дарга буюу төсвийн шууд захирагч гаргаж байх албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 3.** Шатахуун зарцуулалтын нормыг Зам, тээврийн сайдын баталсан жишиг нормын дагуу тооцоогүй, шатахуун зарцуулалтын нормыг тогтоогоогүй 1,140.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" нэгдүгээр хавсралттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт** Зам тээврийн хөгжлийн сайдын "*Жишиг норм батлах тухай*" 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын дагуу тээврийн хэрэгслийн жишиг нормыг шинэчлэн тогтоон ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 4.** 2024 оны төсвийг төсөвлөхдөө байгууллагаас ажилчдын эрүүл мэндийн даатгалд төлөх 1,615.3 мянган төгрөгийг төлөвлөж төсөвт тусгаагүй улмаас зардал хооронд гүйлгэн төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана, 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн.

**Шийдвэрлэлт** Төсвийг төсөвлөхдөө үндсэн үйл ажиллагааны зардлыг зардлын төрөл тус бүрээр нь бүрэн гүйцэт төсөвлөж байх зөвлөмжийг хүргүүлэв.

**Илрүүлэлт 5.** 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас худалдан авсан авто машиныг байгууллагын хөрөнгөд бүртгэсэн боловч өнөөдрийг хүртэл байгууллагын нэр дээр шилжүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх, 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 14.4.1 дэх "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт** Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа автомашиныг байгууллагын нэр дээр шилжүүлэх хүсэлтийг холбогдох байгууллагуудад гаргаж шилжүүлэх зөвлөмж хүргүүлэв.

**Илрүүлэлт 6.** Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулаагүй. /хавсралт файл, бусад мэдээллийг оруулаагүй/.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.1.2 хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;, 6.1.3 дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, ..... нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт** Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай ажил үйлчилгээг шилэн дансны хуулийн дагуу хугацаанд нь мэдээллийг бүрэн гүйцэт оруулж байх зөвлөмж хүргүүлэв.

#### **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

##### **4.1 Дүгнэлт:**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Баруунбүрэн сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны эхний 3 дугаар улирлын санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын ИТХ-ын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

##### **4.2 Шийдвэрлэлт:**

Баруунбүрэн сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 19,399.8 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 17,784.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1,615.3 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.


**Тав.Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:**

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.



Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус сумын ИТХ-ын ажлын албаны дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

**БИЧСЭН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД  
АУДИТОР  Х.БАТБААТАР

**ТАНИЛЦСАН:**

  
БАРУУНБҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
М.МӨНХЦАЦРАЛ  
НЯГТЛАН БОДОГЧ  Б.ОЮУНГЭРЭЛ